

**“ДЦС-4” ТӨХК-ний 2017 оны үйл  
ажиллагааны үр дүнгийн тухай танилцуулга**

**Нэг. Үйлдвэрлэлийн ТЭЗҮ-ийн талаар**

Тус компани нь 2017 оны төлөвлөгөөг Диспетчерийн үндэсний төв, ЭХЗХ болон ЭХЯ-наас баталсан төлөвлөгөөг үндэслэн боловсруулж ТУЗ, ТӨБЗГ-ын хурлаар батлуулан мөрдөн ажиллаж гүйцэтгэлийг гаргалаа.

Тайлант жилд 3,713.7 сая кВтц цахилгаан эрчим хүч боловсруулж, дотоод хэрэгцээнд 12.44% буюу 461.8 сая кВтц цахилгаан эрчим хүч хэрэглэн 3,251.9 сая кВтц цахилгаан эрчим хүч, 3,569.4 мянган Гкал дулааны эрчим хүч түгээхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 3,805.9 сая кВтц цахилгаан эрчим хүч боловсруулж, дотоод хэрэгцээнд 12.28% буюу 467.2 сая кВтц цахилгаан эрчим хүч хэрэглэн 3,338.7 сая кВтц цахилгаан эрчим хүч түгээж төлөвлөгөөг 102.7%-аар, 3,508.5 мянган Гкал дулааны эрчим хүч түгээж төлөвлөгөөний гүйцэтгэл 98.3%-ийн биелэлттэй байна.

Техник эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл: боловсруулсан цахилгаан эрчим хүч 176.7 сая кВтц, түгээсэн цахилгаан эрчим хүч 162.4 сая кВтц-аар нэмэгдэж, түгээсэн дулааны эрчим хүч 23.9 мянган Гкал-аар буурсан байна.

“ДҮТ” ХХК-д 3,311.6 сая кВтц ЦЭХ худалдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 155.9 сая кВтц-аар нэмэгдсэн байна.

Тайлант жилд ажилласан ТЭЗҮ-ийн байдлыг авч үзвэл:

ЦЭХ-ний түгээх төлөвлөгөө “ДҮТ” ХХК-иас өгсөн горимын дагуу түгээлтийг 101.2%, ДЭХ-ний төлөвлөгөөг 100% биелүүлсэн. СПОТ арилжааны зах зээлд 92,129.5 мянган кВтц цахилгаан эрчим хүч худалдаж, 829.3 мянган кВтц цахилгаан эрчим хүч худалдаж авсан ба арилжаанд 74.4 сая төгрөгийн авлагатай ажиллав.

Тайлант хугацаанд горимд 8 зуух, 7 турбоагрегат ажилласан. Жилийн дундажаар 5.18 зуух, 5.16 турбинтэй ажиллаж 1 зуух бэлтгэлд, турбин бэлтгэлгүй байлаа. Тайлант хугацаанд зуухыг 67 удаа, турбиныг 65 удаа тус тус зогсоожээ.

Түлшний хувийн зарцуулалтыг цахилгаанд /дулаанжуулалтын горимоор/ 4.129 гр/кВтц-аар хэтрүүлж, дулаанд 0.365 кг/Гкал-аар бууруулж 10339 тн-р жишмэл түлш хэтэрсэн.

Жишмэл түлшний хэмнэлт, хэтрэлтийн тооцоог авч үзвэл:

- ДХЦЭХ-ний зарцуулалтыг 0.32%-аар буюу 5.4 сая кВтц-аар хэмнэснээс -2694 т.ж.т
- Уур, усны алдагдлыг 0.89%-аар бууруулж -2306 т.ж.т
- Тэжээлийн усны халууныг 3<sup>0</sup> С-аар дээшлүүлснээр -5248 т.ж.т
- Турбины вакуум 1.71% нэмэгдсэнээс -6251 т.ж.т
- Хурц уурын халуунаас -109 т.ж.т
- Хослон үйлдвэрлэлтийг бууруулснаар +26318 т.ж.т
- Зуухны халуун, хүйтэн галлагаанаас +1260 т.ж.т

- Уурын хувийн зарцуулалт төлөвлөснөөс өссөнөөр -12331 т.ж.т
- Утааны хийн халуун хэлбэлзсэнээс +11700 т.ж.т тус тус хэтрүүлж, хэмнэсэн байна.

Тайлангийн хугацаанд 327 тн мазутын хэмнэлттэй ажилласан.

Түгээсэн цахилгаан, дулааны эрчим хүч нэмэгдэж тоноглолын хүчин чадал ашиглалт дээшилснээр нэгж бүтээгдэхүүнд зарцуулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ төлөвлөгөөт хэмжээнээс буурсан байна.

Тайлант хугацаанд “ДҮТ” ХХК-ийн диспетчерээс 679 удаа нэмэх, 430 удаа хасах даалгавар өгөгдөж 269-663 МВт-ын хооронд ачаалалыг зохицуулан ажиллалаа. Үйлдвэрлэлийн явцад ажиллагаанд байгаа тоноглолын тоо тэдгээрийн хүчин чадал ашиглалтын хувь, түлж буй нүүрсний төрөл чанар гэх мэт олон зүйлээс хамаарч горим хэлбэлзэлтэй байдаг бөгөөд тайлант хугацаанд ашигтай горимоор ажиллаж чаджээ гэж үзэж байна.

Станцын дотоод циклийг нөхөх уур усны алдагдлыг төлөвлөгөөнөөс 0.89%-аар бууруулж 157100 тн химийн цэвэрлэсэн ус хэмнэсэн. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны хэмжээ 4112 тноор өссөн байна. Тайлант онд дотоод зуух дүүргэхээр 8530 м<sup>3</sup> ус өгч осмосын халаагч уурын зарцуулалт 41005 тн байлаа.

Тайлант хугацаанд тоноглолын аваари, саатал, тоног төхөөрөмжийн гэмтэл, ослын шалтгааныг тухай бүр олж акт тогтоон хариуцлага тооцон ажиллаж ирлээ.

Үүнд: аваар 1 удаа, II зэргийн саатал 1 удаа гарсан. Тоног төхөөрөмжийн эвдрэл, саатал, тос, мазут зарцуулалтын зөрчил 58 удаа гарсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тоног төхөөрөмжийн гэмтэл зөрчил 26-р буурсан байна.

Гарсан саатлыг ангилан авч үзвэл:

- Техникийн шалтгаанаар 34 удаа
- Хүний буруутай үйл ажиллагаанаас хамаарсан 5
- Бусад шалтгаанаар 19 зөрчил тус тус гарсан байна.

Тоног төхөөрөмжийн гэмтэл, зөрчил гаргасан нийт 50 хүнтэй хариуцлага тооцон 1,554.5 мянган төгрөгийн торгууль, зөрчлийн актаар холбогдох цехийн шагналын сангаас 4,123.2 мянган төгрөг, гадны байгууллагаас гаргасан зөрчилд 2,090.3 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ тус тус авсан болно.

ТЭЗҮ болон бусад судалгааг хавсаргав.

### **Хоёр. Борлуулалтын орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар**

Компани тайлант хугацаанд орлогын төлөвлөгөөг хэрэглэгчдэд борлуулах үнэ тарифыг ЭХЗХ-ны 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 09 тоот тогтоолоор баталсан

“ДҮТ” ХХК-д худалдах тариф:

Энергийн тарифыг I,II,III улиралд /1-8-р сар/ 21.91 төг/кВт.ц,

Чадлын тарифыг I улиралд 10,700,331.0 мян.төг/сар

II улиралд 7,689,788.0 мян.төг/сар

III улиралд /7-8 сар/ 7,689,788.0 мян.төг/сар

“УБДС” ТӨХК-д худалдах дулааны тарифыг:

I улиралд 12,500.0 төг/Гкал-р

II улиралд 15,500.0 төг/Гкал-р

III улиралд 3,000.0 төг/Гкал-р /7-8 сар/,

Шууд борлуулах тарифыг:

Цахилгаанд: ААН-д худалдах тарифыг ЦЭХ-128,5 төг/кВтц /7-р сар/,

дэмжих тарифыг 3.95 төг/кВтц,

чадлын тарифыг 9,000.0 төг,

Дулаанд: УБ хотын ҮААН-д борлуулах дулааны уурын тарифыг 20,545.0 төг/Гкал-аар

ААН-д худалдах дулаан усаар 27,692.0 төг/Гкал мөрдөж

ажиллсан.

2017 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 218 тоот тогтоолоор баталсан “ДҮТ” ХХК-д худалдах:

Энергийн тариф 48.39 төг/кВтц

Чадлын тарифыг:

III улиралд /9-р сар/ 3,594,403.0 мян.төг/сар

IV улиралд 3,594,403.0 мян.төг/сар

ААН-д худалдах тарифыг: 128.5 төг/кВтц

дэмжих тарифыг 11.88 төг/кВтц,

чадлын тарифыг 9,000.0 төг,

“УБДС” ТӨХК-д худалдах дулааны тарифыг

III улиралд /9-р сар/ 3,400.0 төг/Гкал-р

IV улиралд 8,600.0 төг/Гкал-р

Дэмжих тарифыг ЭХЗХ-ны 2017 оны 7-р сарын 17-ны өдрийн 211 тоот тогтоолоор 7.93 /8-9-р сар/ төг/кВтц-аар нэмж 11,88 төг/кВтц болгон 7 сарын 15-наас цахилгаан эрчим хүчний энергийн тарифийг мөрдөн ажилласан.

Тайлант улиралд үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанаас 232,251.0 сая төгрөгийн борлуулалтын орлого олохоор төлөвлөснөөс 233,272.8 сая төгрөгийн борлуулалт хийж орлогын төлөвлөгөөг 100.4 хувиар биелүүлсэн.

Тайлант жилд үндсэн үйл ажиллагаанаас 8.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөн гүйцэтгэлээр 2,008.1 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Эрчим хүчний нийт борлуулалтын орлогын 83.9%-ийг “ДҮТ” ХХК-тай байгуулсан гэрээ болон төлбөр тооцооны дүнгээр авах орлого бүрдүүлж байгаа бөгөөд орлого цуглуулалтын хувь 109.9%-тай байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулбал 8.4%-аар өссөн байна.

“ДҮТ” ХХК, “УБДС” ТӨХК болон хэрэглэгч компаниудтай байгуулсан бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ болон гэрээний биелэлтээр авах ёстой орлогын 9.4% нь хоорондын тооцоогоор, 0.2% нь кассаар, 90.3% нь харилцахаар орж ирсэн байна.

Худалдсан эрчим хүчний төлбөрийн биелэлтийг хүснэгтээр харуулбал:  
сая төгрөгөөр

Д/д	Үзүүлэлт	Гэрээгээр (бичилтээр)	Гүйцэтгэл	Хувиар	Зөрүү
1	“ДҮТ” ХХК	208,460.9	209,617.9	100.6%	1,157.0
2	“УБДС” ТӨХК	37,340.4	37,755.5	101.1%	415.1
3	Уурын борл.	4,030.2	3,964.4	98.4%	-65.8
4	Өөрийн борл.ЦЭХ	522.3	515.0	98.6%	-7.3
5	Өөрийн борл.ДЭХ	314.3	312.5	99.4%	-1.8
6	“СПОТ” зах зээлд	101.3	96.5	95.3%	-4.8
<b>Дүн:</b>		<b>250,769.4</b>	<b>252,261.8</b>	<b>100.6%</b>	<b>1,492.4</b>

### Гурав. Өртөг зардлын судалгааны талаар

Тайлант онд бүтээгдэхүүний нэгжийн өөрийн өртгийг конденсационный горимоор тооцон 1 кВтц цахилгаан эрчим хүчинд 48.78 төгрөг, 1 Гкал дулааны эрчим хүчинд 20,624.13 төгрөгөөр төлөвлөгдсөн бөгөөд гүйцэтгэлээр 1 кВтц цахилгаан 47.99 төгрөг, 1 Гкал дулаан 20,245.09 төгрөг болж өртөг цахилгаанд 0.78 төгрөгөөр, дулаанд 379.04 төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Төлөвлөгөөтэй харьцуулбал үйл ажиллагааны зардал 978.3 сая төгрөгөөр хэмнэгдэж, үндсэн үйлдвэрлэлийн орлого 1,021.8 сая төгрөгөөр давснаар үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөт ашиг 2,000.1 сая төгрөгөөр өссөн.


Зардлын хэмнэсэн, хэтэрсэн шалтгааныг судалж үзэхэд:

- 1 Түлшний зардал 1,028.9 сая төгрөгөөр хэтэрсэн. 86.8 сая кВтц цахилгаан эрчим хүчийг илүү түгээснээр нийт зарцуулсан нүүрс 18.6 мянган тонноор өсч 717.5 сая төгрөг нүүрсний зардалд, 486,7 сая төгрөг нүүрсний тээврийн зардалд илүү зарцуулсан. Мазутыг 222 тн-оор хэмнэж 124.7 сая төгрөгөөр бууруулсан, вагон ашиглалтыг зохистой хийсний үр дүнд зардлыг 50.6 сая төгрөгөөр бууруулсан.
- 2 Ашиглалтын зардал 165.2 сая төгрөгөөр хэтэрсэн. Үүнээс ашиглалтын цахилгаан эрчим хүчний зардал 447.4 сая төгрөгөөр хэтэрсэн. 3.2 сая кВтц-аар трансформаторын зардал өссөн энэ хэтрэлтийг бий болгож байна.
- 3 Химийн туслах материалын зардлыг 360.9 сая төгрөгөөр хэмнэсэн. Энэ нь станцын боловсруулах усны зарцуулалтаас хамаарч химийн бодисын орцын хэмжээ өөрчлөгдснөөр зардлын хэмнэлт гарсан байна. Тухайлбал: Гидразин гидрат, Хаг хурдсыг удаашруулах бодис, Бактериас сэргийлэх бодис.
- 4 Үндсэн ба нэмэгдэл цалин, НДШ-ийн зардал 120.7 сая төгрөгөөр хэтэрсэн. Энэ хэтрэлт нь аудитын зөвлөмжийн дагуу жилийн үр дүнгийн шагналыг тухайн жилд нь тооцдог болсонтой холбоотой. Мөн НДШ-д зарим шагнал урамшуулалыг хувь хүний орлогод тооцон шимтгэл ноогдуулсан, хоолны хөнгөлөлтийг хувь хүний орлогод тооцон шимтгэл тооцдог болсонтой холбоотой.

- 5 Тос, шатахууны зарцуулалтыг 316.5 сая төгрөгөөр хэмнэсэн нь цех, хэсгүүдийн зарцуулах тос, шатахууны норм, лимитийг өмнөх оны гүйцэтгэлээс хэтрүүлэхгүйгээр мөрдөж байгаа боловч нүүрсний талбайн нөөцөд татаж буй нүүрснээс хамаарсан түлшний зарцуулалт буурснаар зардал хэмнэгдсэн.
- 6 Сэлбэг хэрэгсэл, графикт урсгал засварын зардал 491.9 сая төгрөгөөр хэмнэсэн нь үндсэн ба туслах тоног төхөөрөмж, дулаанжуулалтын тоноглолд ноцтой гэмтэл, саатал гараагүй тогтвортой ажилласантай холбоотой.
- 7 Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал төлөвлөгөөнөөс 377.7 сая төгрөгөөр өссөн. ЭХЗХ-ны 53-р тогтоолыг үндэслэн ажлын хэсэг байгуулагдан компанийн үндсэн хөрөнгийн бүртгэлийн нэршил, ашиглалтын хугацааг тогтоосон.
- 8 Томилолтын зардал 56.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Томилолтыг удирдах дээд байгууллага болон компанийн удирдлагын шийдвэрээр зөвхөн үйлдвэрлэлд чухал ач холбогдол бүхий ажилд явуулсантай холбоотой.
- 9 Конторын хангамжийн зардал 13.1 сая төгрөгөөр хэмнэсэн нь цех, хэсэг, нэгжид лимит тогтоож мөрдөж зардлын хэмнэлтийн бодлого барин ажиллаж буй нь хэмнэлтэд нөлөөллөө. Мөн бичиг хэргийн материалын нийлүүлэлтээс хамаарч байна.
- 10 Холбооны зардлыг 3.2 сая төгрөгөөр хэмнэсэн нь ярианы тогтоосон лимитийг мөрдөж хэтэрсэн тохиолдолд холбогдох албан тушаалтнаас төлбөрийг суутгах арга хэмжээ авч буй нь хэмнэлтэд хүргэжээ.
- 11 Материал хангамжийн зардал 7.3 сая төгрөгөөр хэмнэсэн нь ажлын багаж, хэмжих хэрэгслийн хангалт нийлүүлэлтээс хамаарсан хэмнэлт юм.
- 12 Ажиллагсдын нийгмийн зардал төлөвлөгдсөнөөс 666.3 сая төгрөгөөр хэмнэсэн. Тэтгэмж тусламжийн 384.1 сая төгрөгийн нөөц өр төлбөрийг бууруулж бүртгэсэн нь зардлын гүйцэтгэлд хэмнэгдсэн мэт харагдаж байгаа. Гадны болон өндөр настны тэтгэвэр, хүлээн авалт, олон нийтийн арга хэмжээ, спорт биеийн тамирын арга хэмжээг үйл ажиллагааны бус зардалд тооцсон.
- 13 Орлогын албан татварын зардал 1,516.3 сая төгрөг болсон. Хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөр бүртгэх талаар хараат бус аудитын зөвлөмж өгсний дагуу татварын зориулалтаар байгуулсан элэгдэл, санхүүгийн зориулалтаар байгуулсан элэгдлийн зөрүүгээр хойшлогдсон татварт бичигдэж байгаа татварын хэмжээ 2017 онд 1,516.3 сая төгрөг болсон.

## Дөрөв. Санхүүгийн тайлангийн талаар

2017 оны 12-р сарын 31-ний байдлаар тус компани нь 28,486.6 сая төгрөгийн эргэлтийн, 408,868.2 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй, 29,727.9 сая төгрөгийн богино хугацаат, 204,181.3 сая төгрөгийн урт хугацаат өртэй, 203,445.6 сая төгрөгийн эзэмшигчдийн өмчтэй нийтдээ 437,354.8 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.



## Мөнгөн хөрөнгийн талаар

Нийт мөнгөн орлого зарлагын урсгалыг авч үзвэл:

Үзүүлэлтүүд		2016		2017		Зөрүү	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Мөнгөний орох урсгал	"ДҮТ" ХХК	179,189.3	84.2	193,398.2	84.6	14,208.9	0.4
	"УБДС" ТӨХК	30,102.2	14.1	30,818.8	13.5	716.6	-0.7
	Уурын борлуулалт	2,897.6	1.4	3,406.3	1.5	508.7	0.1
	Өөрийн борлуулалт	565.7	0.3	312.4	0.1	-253.3	-0.1
	Бусад	102.4	0.0	588.9	0.3	486.5	0.2
	<b>Нийт орох урсгал</b>	<b>212,857.2</b>	<b>100.0</b>	<b>228,524.6</b>	<b>100.0</b>	<b>15,667.4</b>	<b>0.0</b>
Мөнгөний гарах урсгал	Цалин	32,578.4	15.1	38,183.5	16.7	5,605.1	1.6
	Нүүрс	91,091.0	42.3	94,535.0	41.4	3,444.0	-1.0
	Тээврийн хөлс	19,615.0	9.1	22,710.0	9.9	3,095.0	0.8
	Сэлбэг хэрэгсэл	29,192.2	13.6	28,281.3	12.4	-910.9	-1.2
	Их засварын хөлс	5,522.0	2.6	6,569.9	2.9	1,047.9	0.3
	НДШ	8,556.1	4.0	10,142.0	4.4	1,585.9	0.5
	НӨАТ	8,265.0	3.8	10,902.1	4.8	2,637.1	0.9
	Бусад татвар	5,425.6	2.5	6,090.8	2.7	665.2	0.1
	<b>Зээл, зээлийн хүү</b>	<b>9,982.5</b>	<b>4.6</b>	<b>5,270.1</b>	<b>2.3</b>	<b>-4,712.4</b>	<b>-2.3</b>

Ажилчдын нийгмийн зардал	2,069.5	1.0	1,357.9	0.6	-711.6	-0.4
Бусад	2,935.5	1.4	4,467.7	2.0	1,532.2	0.6
<b>Нийт гарах урсгал</b>	<b>215,232.8</b>	<b>100.0</b>	<b>228,510.3</b>	<b>100.0</b>	<b>13,277.5</b>	<b>0.0</b>

Энэ тайлант онд касс болон харилцах дансанд нийтдээ 228.5 тэрбум төгрөг төвлөрсөн нь өнгөрсөн оныхоос 15.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 84.6% буюу 193.3 тэрбум төгрөгийг “ДҮТ” ХХК-иас, 13.5% буюу 30.8 тэрбум төгрөгийг УБДС ТӨХК-иас төвлөрүүлсэн байна.

Арилжааны банкуудаас дансны дундаж үлдэгдэлд олгосон хүүгийн орлогод 142.7 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлогыг оллоо.

Жилийн туршид 800 орчим байгууллагад 228.5 тэрбум төгрөгийн төлбөр хийлээ. Мөнгөний хуваарилалтыг авч үзвэл нийт зарцуулалтын 41.4% буюу 94,535.0 сая төгрөгийг нүүрсэнд, 12.4% буюу 28,281.3 сая төгрөгийг сэлбэг материалын үнэнд, 9.9% буюу 22,710.0 сая төгрөгийг тээврийн хөлсэнд тус тус төлжээ.

Төсөвт төлөх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу цаг тухайд нь төлж ирлээ. Татвар төлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулж үзвэл:

сая төгрөгөөр

№	Татварын төрөл	2013	2014	2015	2016	2017	
1	ААНОАТ	34.8	8.0	4.0	7.5	13.7	
2	НӨАТ	мөнгөөр	6,170.2	5,066.2	7,356.0	8,265.2	10,900.0
		хаалтаар	374.5	1,430.7	2,519.8	2,154.1	2,893.9
3	НДШ	6,920.0	7,430.1	7,866.5	8,556.1	10,142.0	
4	ХХОАТатварт	2,994.2	3,020.1	3,419.0	3,736.5	4,325.0	
5	ҮХХ-ийн татварт	779.4	815.9	800.6	824.1	821.1	
6	Газрын татварт	0.0	133.3	118.9	124.5	125.1	
7	Усны нөөц ашигласны төлбөр	0.0	554.0	774.9	630.7	656.5	
8	НХАТ	0.0	0.0	0.0	1.6	1.1	
<b>НИЙТ ДҮН</b>		<b>17,273.1</b>	<b>18,458.3</b>	<b>22,859.7</b>	<b>24,300.3</b>	<b>29,878.4</b>	

2017 онд 29,878.4 сая төгрөгийн татвар, шимтгэлийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өнгөрсөн оныхоос 5,578.1 сая төгрөгөөр өссөн байна.


### Материалын талаар

Бараа материалын эхний эцсийн үдэгдлийг нэр төрөл тус бүрээр нь авч үзвэл:  
сая төгрөгөөр

Төрөл	2016	2017	Зөрүү
Нүүрс	6,195.5	6,370.3	174.8
Мазут	11.6	0.2	-11.4
Үндсэн сэлбэг хэрэгсэл	6,772.1	6,766.6	-5.5
Хангамжийн материал	96.6	109.6	13.0
Шатахуун тосолгооны материал	247.4	242.4	-5.0
Тээвэр машин механизмын сэлбэг	43.8	35.6	-8.2
Химийн сэлбэг	282.2	328.6	46.4
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	105.4	111.6	6.2
Бусад бараа	163.6	201.5	37.9
<b>НИЙТ ДҮН</b>	<b>13,918.2</b>	<b>14,166.4</b>	<b>248.2</b>

Материалын үлдэгдэл 14,166.4 сая төгрөг болж өнгөрсөн оноос 248.2 сая төгрөгөөр өссөн байна. Нүүрсний үлдэгдэл 174.8 сая төгрөг, химийн материал 46.4 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 6.2 сая төгрөг, хангамжийн материал 13.0 сая төгрөгөөр тус тус өсч, мазут 11.4 сая төгрөг, үндсэн сэлбэг материал 5.5 сая төгрөг, шатахуун тосолгооны материал 5.0 сая төгрөг, тээвэр машин механизмын сэлбэг 8.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Бараа материалын 2017 оны үлдэгдэл



2017 онд 3,462.4 мянган тонн нүүрс хүлээн авч 3,451.2 мянган тонныг зарцуулж 178.6 мянган тонн нүүрс талбай дээр үлдсэн нь өнгөрсөн оны үлдэгдлээс биет хэмжээгээр 0.8 мянган тонноор өссөн байна.

### Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг авч үзвэл:

Хөрөнгийн төрөл	2016.12.31		2017.12.31		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
Барилга байгууламж	85,881.4	7.8	84,355.4	7.4	-1,526.0	-0.4
Машин тоног төхөөрөмж	922,677.5	83.3	981,514.0	85.8	58,836.5	2.5
Тээврийн хэрэгсэл	6,144.3	0.6	7,029.2	0.6	884.9	0.1



Тавилга эд хогшил	1,584.0	0.1	1,378.1	0.1	-205.9	0.0
Компьютер бусад хэрэгсэл	1,563.3	0.1	1,427.7	0.1	-135.6	0.0
Бусад үндсэн хөрөнгө	87,641.8	7.9	66,314.1	5.8	-21,327.7	-2.1
Биет бус хөрөнгө	2,235.0	0.2	2,246.7	0.2	11.7	0.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,107,727.3</b>	<b>100.0</b>	<b>1,144,265.2</b>	<b>100.0</b>	<b>36,537.9</b>	<b>0.0</b>
Хуримтлагдсан элэгдэл	699,772.9	63.2	737,801.8	64.5	38,028.9	1.3
Үлдэгдэл өртөг	407,954.4	36.8	406,463.4	35.5	-1,491.0	-1.3

Үндсэн хөрөнгийн дансны үнэ оны эхнээс 1,491.0 сая төгрөгөөр буурч 406,463.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй боллоо.

2017 онд хийгдсэн үндсэн хөрөнгийн өөрчлөлтийг үзүүлбэл:

Гүйлгээний утга		Анхны өртөг	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
<b>2017.01.01-ний үлдэгдэл</b>		<b>1,107,727.3</b>	<b>699,772.9</b>	<b>407,954.4</b>
Нэмэгдсэн	Худалдаж авсан	15,220.3		
	Үнэ төлбөргүй авсан	1,147.2		
	Капиталжуулсан	23,734.2		
	Залруулсан	978,363.6	607,023.1	
Хасагдсан	Үнэгүй шилжүүлсэн	165.0	30.8	
	Акталсан	3,209.3	3,140.3	
	Залруулсан	978,553.1	607,043.5	
2017 онд байгуулсан элэгдэл			41,220.4	
<b>2017.12.31-ний үлдэгдэл</b>		<b>1,144,265.2</b>	<b>737,801.8</b>	<b>406,463.4</b>

Энэ онд 22,316.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ний ажил хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 6,540.5 сая төгрөгөөр буурсан байна.

Д/д	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн тоноглолын их засвар	14,379.6	13,469.3	-910.3
2	Туслах тоноглолын их засвар	6,661.5	6,022.7	-638.8
3	Барилгын их засвар	1,339.8	538.3	-801.5
4	ТЗБАХ	642.0	489.0	-153.0

5	Хөрөнгө оруулалт	5,834.5	1,797.6	-4,036.9
	<b>Дүн</b>	<b>28,857.4</b>	<b>22,316.9</b>	<b>-6,540.5</b>

Дуусаагүй барилгын дансанд 2,404.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Д.д	Дуусаагүй ажлын нэр	Дүн /сая төгрөг/	Тайлбар
1	МОН Р10 төслийн ажил	295.5	Төслийн ажил дуусаагүй
2	ПЭН-9-ийн сэлбэг	1,058.5	Төслийн ажил дуусаагүй
3	Галлагааны уурын ерөнхий шугам ТА-1-4-ийн шинэчлэлийн ажил	1,050.5	Төслийн ажил дуусаагүй

### Өр, авлагын талаар

Авлагын үлдэгдлийг төрөл тус бүрээр нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал:

сая төгрөгөөр

Авлагын төрөл	2016.12.31	2017.12.31	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
“ДҮТ” ХХК	7,422.0	6,265.1	-1,156.9	-15.6
Уурын авлага	378.5	445.3	66.8	17.6
Жижиг хэрэглэгч	51.1	35.4	-15.7	-30.7
Байгууллагаас авах авлага	341.9	317.6	-24.3	-7.1
Хувь хүмүүсээс авах авлага	43.2	18.6	-24.6	-56.9
Бусад авлага	29.8	37.3	7.5	25.2
<b>Нийт авлага</b>	<b>8,266.5</b>	<b>7,119.3</b>	<b>-1,147.2</b>	<b>-13.9</b>
Найдваргүй авлагын нөөц	825.0	706.4	-118.6	-14.4
<b>Цэвэр авлагын дүн</b>	<b>7,441.5</b>	<b>6,412.9</b>	<b>-1,028.6</b>	<b>-13.8</b>

Тайлант хугацаанд 7,119.3 сая төгрөгийн авлагатай байна. Нийт авлага өнгөрсөн оны мөн үеэс 1,147.2 сая төгрөгөөр буюу 13,9%-иар буурсан байна. Авлагын 88.2%-ийг эрчим хүчний борлуулалтын авлага, 6.8%-ийг үйлдвэрийн байгууллагаас авах авлага, 5.1%-ийг бусад авлага эзэлж байна.

“ДҮТ” ХХК-иас авах авлагын дүн 6,265.1 сая төгрөгт хүрч өнгөрсөн оныхоос 1,156.9 сая төгрөгөөр буурсан.

Энэ онд “ДҮТ” ХХК-д НӨАТ-тай дүнгээр 208,460.9 сая төгрөгийн ЦЭХ-ийг борлуулсан байна. “ДҮТ” ХХК нь 208,460.9 сая төгрөгийн төлбөр хийж борлуулалтын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөг 100,6%-иар биелүүлж, хуримтлагдсан авлагыг 1,156.9 сая төгрөгөөр буурууллаа. Нийт төлбөрийн 92% буюу 193,398.2 сая төгрөгийг

харилцах дансанд мөнгөөр, 8% буюу 16,219.6 сая төгрөгийг хоорондын тооцооны хаалтаар хийсэн байна.

УБДС ТӨХК нь борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлж ажилласан. Энэ онд УБДС ТӨХК-д НӨТ-тэй 37,340.4 сая төгрөгийн борлуулалт хийж борлуулалтын орлогоо бүрэн цуглууллаа. Нийт төлбөрийн 82.5% буюу 30,818.8 сая төгрөгийг харилцах дансанд мөнгөөр, 17.5% буюу 6,521.6 сая төгрөгийг хоорондын тооцоогоор хийлээ.

Богино хугацаат өглөгийг төрөл тус бүрээр нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал:

Төрөл	2016.12.31	2017.12.31	сая төгрөгөөр Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Дансны өглөг	11,107.2	10,855.4	-251.8	-2.3
Татвар НДШ-ийн өглөг	546.3	474.4	-71.9	-13.2
Цалингийн өр /жилийн үр дүн/	0.0	2,245.2	2,245.2	0.0
УХЗээлийн тайлант үеийн өр	0.0	9,264.2	9,264.2	0.0
Хүүгийн өглөг	0.0	2,117.5	2,117.5	0.0
Нөөц өр төлбөр	296.1	530.8	234.7	79.3
Урьдчилж орсон орлого	42.3	4,235.6	4,193.3	9,913.2
Бусад	0.0	4.8	4.8	0.0
Нийт өглөг	11,991.9	29,727.9	17,736.0	147.9

Богино хугацаат өр төлбөр балансын дүнгээр 29,727.9 сая төгрөг буюу оны эхнээс 17,736.0 сая төгрөгөөр өссөн. Энэ нь урт хугацаат зээлийн тайлант үед төлөх үндсэн болон хүүгийн төлбөрийн 11,381.4 сая төгрөг, ТӨБЗГ-ийн шийдвэрийн дагуу ТАНЭ7-н 4,266.3 сая төгрөгийн хойшлогдсон орлогод, Тэтгэвэр тэтгэмжийн нөөц өр төлбөрт 530.8 сая төгрөгийг тус тус бүртгэсэн байна.

Хэрвээ эдгээр зардлуудыг тооцохгүй бол өглөгийг өмнөх оноос 657.8 сая төгрөгөөр бууруулсан байна. Үүнд: ШОНУ-н хуримтлагдсан нүүрсний өр төлбөр 1,387.4 сая төгрөгөөс 713.0 сая төгрөгөөр бууруулсан. Бэлтгэн нийлүүлэгчийн өр төлбөр 9,452.0 сая төгрөг болж өнгөрсөн оноос 620.3 сая төгрөгөөр өссөн.

ТӨБЗГазрын тогтоолоор ТА-7 –той холбоотой хөрөнгийг НББОУС-20 заасны дагуу орлогын аргаар бүртгэх шийдвэр гарснаар 119,151.9 сая төгрөгөөр эздийн өмчийг бууруулж, тайлант жилийн элэгдлийн зардлыг урьдчилж орсон орлогод бүртгэсэн, урт хугацаат зээлийн тайлант үеийн болон хүүгийн өглөг, ажилчдын тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой нөөц өр төлбөрийн дансууд өсөхөд нөлөөллөө.

Багануурын уурхайн нүүрсний төлбөр, төмөр замын тээврийн хөлс, засварын ажлын хөлс, тендерийн сэлбэг материал, татвар нийгмийн даатгал бусад төлбөр тооцоонуудыг гэрээний болон хуулийн хугацаанд барагдуулж үлдэгдлийг бууруулахад гол анхаарлаа хандуулж ажиллалаа.

Дамжуулан зээлдүүлэх төслийн зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг графикийн дагуу бүрэн төлсөн.

Зээлийн тооцоог төсөл тус бүрээр авч үзвэл.

сая төгрөгөөр

Зээл олгогч	Зээлийн зориулалт	Эхний үлдэгдэл 2017.01.01	Төлөлт		Эцсийн үлдэгдэл 2017.12.31
			Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	
Сангийн яам	Зуухны шинэчлэл МОН Р3	11,573.2	2,571.8	446.9	9,001.4
Сангийн яам	Зуухны шинэчлэл МОН Р6	45,722.0	2,344.7	583.4	43,377.3
УБДС ТӨХК	ДҮАТ -1548	6,312.4	314.1	146.8	5,998.3
УБДС ТӨХК	ЭХХТ-1492	1.9	0.1	0.0	1.8
ЦДҮС ТӨХК	ЭХХ-1	271.1	13.6	5.4	257.5
Хөгжлийн банк	З-ДС-ХО 2015-74/1	20,433.7	3,953.1	1,298.1	15,681.1
Сангийн яам	ЭХҮАшиг II	11,449.4	0.0	0.0	20,225.4
<b>Нийт дүн</b>		<b>95,763.8</b>	<b>9,197.4</b>	<b>2,480.5</b>	<b>94,542.9</b>

НББОУС-ын дагуу 2018 онд төлөх зээлийн үндсэн төлбөр болох 9,264.2 сая төгрөгийг урт хугацаат өглөгөөс богино хугацаат өглөгт шилжүүлэн бүртгэлээ.

### Дүгнэлт:

1. 2017 онд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлтийн төлөвлөгөөг 102.5%, цахилгаан эрчим хүчний түгээлтийг 102.7% буюу 86.8 сая кВтц-аар давуулан, дулаан түгээлтийг 98.3% буюу 60.9 мянган Гкал-аар дутуу түгээсэн. Дотоод хэрэгцээний ЦЭХ-ний хувьд 0.16 нэгж хувь буюу 5.4 сая кВтц-аар хэмнэсэн.
2. Тайлант хугацаанд борлуулалтын орлогыг төлөвлөгөөнөөс 2,513.7 сая төгрөгөөр давуулан биелж үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөт ашгийг 2,854.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж 1,345.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.
3. Борлуулсан бүтээгдэхүүний орлого цуглуулалт 109.9% болж өнгөрсөн оны мөн үеэс 8.4 хувиар өссөн. Үүнд: "ДҮТ" ХХК-д худалдсан ЦЭХ-ний орлого нийт орлогын 83.9%-ийг эзэлж байна. Гэвч худалдан авагчаас авах авлага 9-11 саруудад 4,095.3 сая төгрөгөөр өссөн нь оны эцэст санхүүгийн хүндрэлийг үүсгэж байлаа.
4. Цахилгаан эрчим хүчний өөрийн өртгийг төлөвлөснөөс 0.78 төгрөгөөр, дулааны эрчим хүчний өөрийн өртгийг 379.04 төгрөгөөр бууруулж техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангаж ажилласан.
5. Тайлант хугацаанд 7,119.3 сая төгрөгийн авлагатай гарлаа. Авлагын 88.0%-ийг эрчим хүчний борлуулалтын авлага, 6.8%-ийг үйлдвэрийн байгууллагаас авах авлага, 5.1%-ийг бусад авлага эзэлж байна. Эрчим хүчний борлуулалтын авлага нь өнгөрсөн оны мөн үеэс 1,146.1 сая төгрөгөөр буурсан. Нийт авлага өнгөрсөн оны мөн үеэс 1,147.2 сая төгрөгөөр буюу 13,9%-иар буурсан байна.
6. Бэлтгэн нийлүүлэгч болон бусад харилцагч байгууллагуудад 29,727.9 сая төгрөгийн өглөгтэй гарлаа. Үүнээс: ШОНУ-д өгөх нүүрсний төлбөрт 1,387.4 сая төгрөгийн өртэй ба оны эхнээс 713.0 сая төгрөгөөр буурсан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал нийт өглөг 17,736.0 сая төгрөгөөр өссөн. Энэ нь урт хугацаат зээлийн тайлант жилд төлөх зээл, зээлийн хүүгийн төлбөрийн 11,381.4 сая төгрөг, ТА-7-тай холбоотой 119,151.9 сая төгрөгийн хөрөнгийг орлогын аргаар бүртгэсэнтэй холбоотойгоор 4,235.6 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрсөн, 2017 оны жилийн үр дүнгийн шагналд олгох 2,245.2 сая төгрөгийг цалингийн өглөгөөр хүлээн зөвшөөрч богино хугацаат өр төлбөрт бүртгэсэн нь нөлөөллөө.
7. Шинжилгээний үзүүлэлтээс эргэлтийн харьцаа, түргэн хөрвөх чадварын харьцаа, авлага цуглуулах хугацаа, өглөг барагдуулах хугацаа, өр өмчийн харьцаа эерэг харьцаатай, харин өмчийн өгөөж, ахиуц ашиг сөрөг харьцаатай байна. Шинжилгээний үзүүлэлтүүд өмнөх оноос сайжирсан үзүүлэлттэй байгаа боловч зохистой үзүүлэлтийн түвшинд хүрээгүй байгаа бөгөөд орлого төвлөрүүлэлтийг улам сайжруулж, ашгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
8. 2017 онд тоноглолын угсралт дуусаад байсан боловч ашиглалтад бүрэн хүлээн аваагүй байсан Эсрэг осмосын тоног төхөөрөмжийг улсын комиссын актын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэж авсан.
9. ЭХЗХ-ны шалгалтын акт, Аудитын зөвлөмжүүдийн дагуу зөрчлийг арилгуулах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн.